ХААН БАНК

ХААН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр № 01 Улаанбаатар хот

Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.9 дэх заалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал банкны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9-т Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

1. **ТОГТООХ НЬ:** “Прайсуотерхаускуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.

2. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлөөс өргөн барьсан Банкны 2023 оны үйл ажиллагааны талаарх тайланг үүгээр баталсугай.

3. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.ДАРЬБУМ

МОНГОЛ УЛС 2693321 ХААН БАНК ХК

ХААН БАНК

ХААН БАНКНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр
сарын 23-ны өдөр № 02 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах тухай

ҮНДЭСЛЭЛ: : Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.13-т Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-ийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

1. **ТОГТООХ НЬ:** “ХААН Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу батлсугай.

2. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.ДАРЬБУМ

МОНГОЛ УЛС 6243061249 1176099 2693321 ХААН БАНК ХК

ХААН БАНК

ХААН БАНКНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр
сарын 23-ны өдөр № 03 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалтад Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.13-т Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-ийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ИЙНХҮҮ:

1. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.

2. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Ариунтулга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.ДАРЬБУМ

МОНГОЛ УЛС ХТУ6099 9023061249 2693321 ХААН БАНК ХК